



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 49,000,000.00 (дөчин есөн сая) төгрөгийн балансын үнэ, 7,699,999.94 (долоон сая зургаан зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Б.Гаваад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 07 дугаар сарын 08 -ны өдрийн  
 357 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
 ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны нэр, марк, улсын бүртгэл, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он, ашиглалтад орсон он	Нийт гуйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Форд транзит, 48-91 ОРХ (арал-wfoaxhgbvask94499)	1996/2015	188542	49,000,000.00	7,699,999.94	41,300,000.06	42,000,000.00
	Нийт дүн			49,000,000.00 (дөчин есөн сая)	7,699,999.94 (долоон сая зургаан зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн дөрвөн мөнгө)	41,300,000.06 (дөчин нэгэн сая гурван зуун мянган төгрөг зургаан мөнгө)	42,000,000.00 (дөчин хоёр сая)